



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadags@audit.gov.mn](mailto:serjmyadags@audit.gov.mn)  
Аудитор: Д.Зэндмэнэ  
Утас: 260512 Цахим хаяг: [zendmened@audit.gov.mn](mailto:zendmened@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Юнистар аудит ХХК  
Захирал М.Энжжаргал  
Утас: 11-328735 Цахим хаяг: [info@unistaraudit.mn](mailto:info@unistaraudit.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## **Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Албан шаардлага.....	20
4.3 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ТУЛГАА  
ТАНАА

2022.02.24 № 07/292  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>214,261,060.00</u></b>	<b><u>26,275,787.30</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	800,000.00	9,052,091.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	800,000.00	209,011.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,843,079.70
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	203,818,962.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	203,818,962.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,642,098.00	17,223,696.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	579,500.00	579,500.00
35110	Тусгай зориулалттай материал	579,500.00	579,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,062,598.00	16,644,196.00
35410	Бичиг хэргийн материал	1,184,198.00	7,318,796.00
35420	Аж ахуйн материал	1,053,300.00	1,100,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,496,500.00	5,636,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,260,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,328,600.00	1,328,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>113,045,468.49</u></b>	<b><u>98,293,670.88</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	113,045,468.49	98,293,670.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	112,107,968.39	97,981,170.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,050,000.00	33,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,935,750.35)	(33,050,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	519,616,170.05	522,890,970.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(416,159,015.05)	(426,835,964.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,513,577.00	18,513,577.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,727,013.26)	(17,337,411.87)
39217	Ном	750,000.00	750,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	937,500.10	312,500.14
39301	Програм хангамж	3,270,000.00	3,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,332,499.90)	(2,957,499.86)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>327,306,528.49</u></b>	<b><u>124,569,458.18</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>327,306,528.49</u></b>	<b><u>124,569,458.18</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	327,306,528.49	124,569,458.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	585,204,089.50	585,204,089.50
51101	Өмч: - төрийн	585,204,089.50	585,204,089.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(282,484,866.59)	(485,221,936.90)
51210	Өмнөх үеийн үр дүн	(281,383,542.65)	(489,113,078.24)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,101,323.94)	3,891,141.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,587,305.58	24,587,305.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>327,306,528.49</u></b>	<b><u>124,569,458.18</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>759,933,222.24</b>	<b>936,129,177.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,907,060.00</b>	<b>673,204.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,907,060.00	673,204.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,907,060.00	673,204.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,907,060.00	-
120009	Бусад орлого	-	673,204.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>748,026,162.24</b>	<b>935,455,973.70</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	719,982,700.00	732,276,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	719,982,700.00	732,276,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,043,462.24	203,179,173.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28,043,462.24	47,845,673.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	102,565,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	52,768,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>761,034,546.18</b>	<b>932,238,036.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>761,034,546.18</b>	<b>932,238,036.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	711,265,604.62	914,895,083.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	605,533,762.27	639,522,913.93
210101	Үндсэн цалин	417,265,200.27	468,301,517.33
210102	Нэмэгдэл	164,551,433.00	115,338,164.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,717,129.00	55,883,232.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,044,187.43	80,802,385.65
210201	Тэтгэврийн даатгал	18,066,350.03	54,832,894.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,327,100.00	6,565,963.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,061,700.00	5,238,970.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,400.00	1,266,831.24
210205	Эрүүл мэндийн даатгал	12,323,637.40	12,897,725.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,063,300.00	7,967,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,370,200.00
210302	Түлш, халаалт	3,374,700.00	3,037,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,560,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,731,408.74	49,672,410.00
210401	Бичиг хэрэг	229,700.00	33,270,910.00
210402	Тээвэр, шатахуун	130,000.00	7,871,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,216,408.74	4,790,700.00
210404	Ном, хэвлэл	3,055,000.00	3,200,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,300.00	45,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	224,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,140,000.00	149,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,140,000.00	149,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	5,714,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	5,714,000.00
210702	Дотоод албан томилолт	-	5,714,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	31,346,062.24	115,849,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,324,062.24	113,827,826.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	21,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,406,883.94	15,217,347.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,406,883.94	15,217,347.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	49,768,941.56	17,342,952.82
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,385,500.00	1,107,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,500.00	1,107,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	48,383,441.56	16,235,952.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,383,441.56	16,235,952.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(1,101,323.94)</u></b>	<b><u>3,891,141.34</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(1,101,323.94)</u></b>	<b><u>3,891,141.34</u></b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	585,204,089.50	24,587,305.58	(281,383,542.65)	328,407,852.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(281,383,542.65)</b>	<b>328,407,852.43</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,101,323.94)	(1,101,323.94)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(282,484,866.59)</b>	<b>327,306,528.49</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(282,484,866.59)</b>	<b>327,306,528.49</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(206,628,211.65)	(206,628,211.65)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(489,113,078.24)</b>	<b>120,678,316.84</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	3,891,141.34	3,891,141.34
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>585,204,089.50</b>	<b>24,587,305.58</b>	<b>(485,221,936.90)</b>	<b>124,569,458.18</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>748,026,162.24</u></b>	<b><u>936,129,177.70</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>673,204.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	673,204.00
120009	Бусад орлого	-	673,204.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>748,026,162.24</b>	<b>935,455,973.70</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	719,982,700.00	732,276,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	719,982,700.00	732,276,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,043,462.24	203,179,173.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28,043,462.24	47,845,673.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	102,565,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	52,768,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>748,026,162.24</u></b>	<b><u>932,854,377.70</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>748,026,162.24</b>	<b>932,854,377.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>698,257,220.68</b>	<b>915,511,424.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	606,333,762.27	618,195,610.93
210101	Үндсэн цалин	418,065,200.27	446,974,214.33
210102	Нэмэгдэл	164,551,433.00	115,338,164.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,717,129.00	55,883,232.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,044,187.43	81,011,397.25
210201	Тэтгэврийн даатгал	18,066,350.03	55,041,906.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,327,100.00	6,565,963.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,061,700.00	5,238,970.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,400.00	1,266,831.24
210205	Эрүүл мэндийн даатгал	12,323,637.40	12,897,725.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,063,300.00	7,967,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,370,200.00
210302	Түлш, халаалт	3,374,700.00	3,037,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,560,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,531,208.74	17,362,600.00
210401	Бичиг хэрэг	206,500.00	391,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,216,408.74	1,698,700.00
210404	Ном, хэвлэл	3,055,000.00	15,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,053,300.00	172,600.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,373,000.00	373,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,373,000.00	373,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	7,647,130.00
210702	Дотоод албан томилолт	-	7,647,130.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	31,911,762.24	182,954,286.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,889,762.24	180,932,486.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	21,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,768,941.56</b>	<b>17,342,952.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,385,500.00	1,107,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,500.00	1,107,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	48,383,441.56	16,235,952.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,383,441.56	16,235,952.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>===== -</b>	<b>===== 3,274,800.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>===== -</b>	<b>===== -</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>3,274,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,274,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	3,274,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,274,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>===== -</b>	<b>===== (3,274,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	732,276,800.00	716,048,407.18	(16,228,392.82)
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	732,276,800.00	716,048,407.18	(16,228,392.82)
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	731,168,400.00	714,941,407.18	(16,226,992.82)
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	619,719,400.00	607,345,342.93	(12,374,057.07)
210101	Үндсэн цалин	480,359,500.00	436,123,946.33	(44,235,553.67)
210102	Нэмэгдэл	127,404,800.00	115,338,164.60	(12,066,635.40)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,955,100.00	55,883,232.00	43,928,132.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,417,100.00	79,739,264.25	(3,677,835.75)
210201	Тэтгэврийн даатгал	58,108,300.00	53,769,773.20	(4,338,526.80)
210202	Тэтгэмжийн даатгал	6,327,200.00	6,565,963.19	238,763.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,061,800.00	5,238,970.65	177,170.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,400.00	1,266,831.24	1,431.24
210205	Эрүүл мэндийн даатгал	12,654,400.00	12,897,725.97	243,325.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,967,400.00	7,967,400.00	-
210301	Гэрэл, цахилгаан	3,370,200.00	3,370,200.00	-
210302	Түлш, халаалт	3,037,200.00	3,037,200.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,560,000.00	1,560,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,362,600.00	17,362,600.00	-
210401	Бичиг хэрэг	372,400.00	391,300.00	18,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,740,200.00	-	(1,740,200.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,698,700.00	1,698,700.00
210404	Ном, хэвлэл	15,100,000.00	15,100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	172,600.00	22,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	373,000.00	373,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	373,000.00	373,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,328,900.00	2,153,800.00	(175,100.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,500.00	132,000.00	(12,500.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-	(59,400.00)

210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	21,800.00	(78,200.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	-	(25,000.00)
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,108,400.00	1,107,000.00	(1,400.00)
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,108,400.00	1,107,000.00	(1,400.00)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,108,400.00	1,107,000.00	(1,400.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	732,276,800.00	716,048,407.18	(16,228,392.82)
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	732,276,800.00	716,048,407.18	(16,228,392.82)
131001	Улсын төсвөөс санхүүжих	732,276,800.00	716,048,407.18	(16,228,392.82)
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>			
610001	Төсвийн байгууллага	1	1	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	46	46	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	-
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>203,171,613.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>203,171,613.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		194,320,974.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		10,177,064.00
210101	Үндсэн цалин		10,177,064.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		1,272,133.00
210201	Тэтгэврийн даатгал		1,272,133.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		7,647,130.00
210702	Дотоод албан томилолт		7,647,130.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		175,224,647.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		175,224,647.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>8,850,639.70</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>8,850,639.70</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		8,843,079.70
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		7,560.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		203,171,613.70
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		203,171,613.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		47,845,673.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		102,557,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		52,768,500.00



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн бүртгэл, үнэлгээг стандартад нийцүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар аудит ХХК-ийн аудитын баг гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Н.Болормаа, ахлах аудитор М.Энхжаргал нар хэрэгжүүлсэн.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Анагаах ухааны хүрээлэн нь эрдэм шинжилгээ-эмнэл зүй-сургалт гэсэн гурвалсан чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улсын төсвөөс санхүүждэг анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээний байгууллага юм.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь:

- Анагаах ухааны ухааны эрдэм шинжилгээ, сургалт, эмнэл зүйн тусламж үйлчилгээг хослуулан ажиллах,
- Монгол улсын анагаах ухааны хөгжил, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудалд чиглэсэн эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгаа хийх,
- Цөм технологи, инновацийн ажлыг өндөр түвшинд хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх,
- Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжлийн ур чадвар, чадавхийг сайжруулах,
- Салбар хоорондын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол;
- “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”;
- БШУС-ын 2021 оны А/22 дугаар тушаалаар Боловсрол шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Анагаах Ухааны Хүрээлэн нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 тоот тушаалаар батлагдсан Боловсрол шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг ба уг бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Анагаах ухааны хүрээлэн нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд харьяа болон санхүүжүүлэгч дээд байгууллага болох Боловсрол шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан технологийн сан, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль зэрэг газруудын хяналт шинжилгээ, дотоод аудитын нэгжээс дотоод аудит, хяналт үнэлгээ хийгээгүй байна.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 761,034.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,610.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Анагаах Ухааны Хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,737.0 мянган төгрөгөөр буюу 61.9 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
А	1	2	3=2-1	4=3/1*100
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авллага	800.00	9,052.1	8,252.1	1,031.5
Урьдчилгаа	203,819.00	-	(203,819.0)	(100.0)
Бараа материал	9,642.1	17,223.7	7,581.6	78.6
Үндсэн хөрөнгө	113,045.4	98,293.7	(14,751.8)	(13.1)

Нийт хөрөнгө	327,306.5	124,569.5	(202,737.1)	(61.9)
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	327,306.5	124,569.5	(202,737.0)	(61.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	327,306.5	124,569.5	(202,737.0)	(61.9)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 9,052.1 мянган төгрөг болж 8,252.1 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 8,843.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага 209.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 203,819.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад хуримтлагдсан 203,819.0 мянган төгрөгийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөгөөр өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд хааж бүртгэсэнээс шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 17,223.7 мянган төгрөг болж 7,581.6 мянган төгрөгөөр өссөн нь эрдэм шинжилгээний ном бүтээл орлогод авсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 98,293.7 мянган төгрөг болж 14,751.8 мянган төгрөгөөр буурсан нь 15,217.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсан.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 124,569.5 мянган төгрөг болж буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр урьдчилж төлсөн зардал данснаас 203,819.0 мянган төгрөгийг өмнөх үр дүнд хаасан.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэн 2021 оны санхүүжилтийг 1,503,736.0 мянган төгрөг, үүнээс үндсэн үйл ажиллагаанд 1,438,550.9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 65,185.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 770,752.7 мянган төгрөгөөр бууруулан 732,983.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор нийт зарлагыг 706.5 мянган төгрөгөөр бууруулж 732,276.8 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх шинжлэх ухаан технологийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 732,276.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 732,276.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 716,048.4 мянган төгрөгийг зарцуулж 16,228.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

дд	Төсөл арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан технологи	732,276.8	716,048.4	16,228.4	97.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагаа	731,168.4	714,941.4	16,227.0	97.8
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,108.4	1,107.0	1.4	99.9

Төсвийн нийт зардал 716,048.4 мянган төгрөг буюу 97.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цалин нэмэгдлийн зардлыг 12,374.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,677.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 175.1 мянган төгрөгөөр дутуу тус тус зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсвийг дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас байгууллагын үйл ажиллагаа хумигдсан, зарим ажилтан зайнаас ажилласан зэрэг нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Австрали улсад төвтэй Дэлхийн эрүүл мэндийн төлөөх Жорж институтээс эрдэм шинжилгээний 1 төсөлд 47,845.6 мянган төгрөг, ЭМЯ-аас эрдэм шинжилгээний 2 төсөлд 52,768.5 мянган төгрөг, ШУТС-гаас эрдэм шинжилгээний 5 ажлын санхүүжилтэд 102,565.0 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 203,179.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

Үүнээс төслийн ажиллагсдын цалин урамшуулал, нийгмийн даатгалын зардалд 11,449.2 мянган төгрөг, судалгааны ажлын томилолтод 7,647,1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг үйлчилгээний төлбөр буюу эм урвалж, шатахуун, хэвлэл материалын зардалд 175,224.6 мянган төгрөг зарцуулж, 8,850.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 7.56 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчид буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Анагаах ухааны хүрээлэн нь төсвийн жилд шинжлэх ухаан технологийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний 8 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ төлөвлөж, зорилтот түвшин, хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийг тайлагнасныг харьяа дээд байгууллага болох АШУҮИС-ийн хяналт шинжилгээ үнэлгээний газар 98.8 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлжээ.

Хөтөлбөр арга хэмжээний зорилтын биелэлт 98.8 хувь, төсвийн гүйцэтгэл 97.8 хувь, зорилт болон төсвийн гүйцэтгэлийн зөрүү 1.0 хувь байгаа нь төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүн хангагдсаныг харуулж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Анагаах ухааны хүрээлэн нь удирдлага зохион байгуулалтын хувьд АШУҮИС-ийн харьяа байгууллага бөгөөд байгууллагын төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг тус сургуулийн захирал үнэлж батладаг байна.

Гэтэл тус хүрээлэнгийн төсвийн төвлөрүүлэн захирагч нь ШУТС-гийн захирал байна. Удирдлага зохион байгуулалт, төсвийн харьяаллын хувьд салангид байгаа нь төсвийн хяналтын үр нөлөө хангалттай хэрэгжихгүй байх шалтгаан болж болзошгүйг цаашид анхаарах шаардлагатай.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Анагаах ухааны хүрээлэн нь 2021 онд нийт 1,148,780.2 мянган төгрөгийн 54 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 54 мэдээлэл байршуулсан боловч 200,383.5 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 380,583.3 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илрүүлснээс 43,896.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 336,686.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад үндсэн хөрөнгийн бүртгэл болон Шилэн данстай холбоотой 2 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10,244.6 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 95.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	10,244.6	2	10,244.6	100	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	95.0	-	-	5
Нийт дүн	2	10,244.6	2	10,244.6	100	-	-	-

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Тус хүрээлэнд БШУЯ, ШУТС болон бусад эх үүсвэрийн нэмэлт санхүүжилтээр хэрэгжиж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны төслүүдийн төсвийн зарцуулалт, тайлагналыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 220,974.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 215,534.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5,440.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн стандарт зөрчсөн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгийн бүртгэл, стандарттай холбоотой 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5,440.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 7,610.0 мянган төгрөгөөс 2,170.0 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлагналтай холбоотой дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл, төслийн хуримтлагдсан зардал 203,818.9 мянган төгрөгийг БШУС-ын 2021 оны А/22 тоот тушаалаар батлагдсан салбарын НБББББ-т заасны дагуу хүлээн зөвшөөрч тайлагнаагүй, үлдэгдлээр бүртгэсэн;
- Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн 8,850.6 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын дүнд оруулж тайлагнасан.
- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн элэгдлийг 2,864.9 мянган төгрөгөөр илүү байгуулж зардлаар бүртгэсэн.

#### 4.2 Албан шаардлага

Төслийн санхүүжилтээр худалдан авсан 5,440.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансанд бүртгэж бөөн дүнгээр зарлагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Бараа материал, шатахууныг анхан шатны баримтанд үндэслэн бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.



#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих дараах асуудлаар зөвлөмж өгөв.

##### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн 336,686.7 мянган төгрөгийн дансны үнэтэй 136 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3. “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1. “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн 336,686.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг УСНББОУС1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтад нийцүүлэн үнэлж шийдвэрлэх, бүртгэж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн мянган төгрөг		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтээс буцаан төвлөрүүлсэн 8,850,639.7 төгрөгийг зардлаар тайлагнасан.	Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг залруулсан	1	8,850.6	1	8,850.6								
2	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн элэгдлийг 2,864,870.47 төгрөгөөр илүү тооцоолж зардлаар бүртгэсэн.	Орлого үр дүнгийн тайланд бууруулж залруулсан.	1	2,864.9	1	2,864.9								
3	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Төслийн өмнөх үеийн УГЗ 203,818,962.0 төгрөгийг НБББББ-т заасны дагуу зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	Санхүүгийн байдлын тайлан, өмнөх үеийн үр дүнд хааж залруулсан.	1	203,818.9	1	203,818.9								
4	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Төслийн санхүүжилтээр авсан шатахууны орлого зарлагыг бөөн дүнгээр бүртгэсэн.		1	5,440.0					1	5440.0				
5	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 336.686.7 мянган төгрөгийн дансны үнэтэй 136 ширхэг хөрөнгө байгааг стандарт, журмын дагуу шийдвэрлээгүй.		1									1		
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					5	220,974.4	3	215,534.4	0	0	1	5,440.0	0	0	1	0

Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 1,148,780.2 мянган төгрөгийн 54 мэдээлэл байршуулсан, 200,383.5 мянган төгрөгийн 12 мэдээлэл хоцроож байршуулсан. Үнэлгээ 95 %		1	200,383.5					1	200,383.5	1	200,383.5		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын дүн					1	200,383.5	0	0	0	0	1	200,383.5	1	200,383.5	0	0
<b>Нийт дүн</b>					<b>6</b>	<b>421,357.9</b>	<b>3</b>	<b>215,534.4</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>2</b>	<b>205,823.5</b>	<b>1</b>	<b>200,383.5</b>	<b>1</b>	<b>0.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 18/A0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/61/ЧА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 онд нийт 1,148,780,237.92 төгрөгийн 54 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 200,383,511.00 төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргасан, аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдээгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 дахь заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Б.Оюунжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Анагаах ухааны хүрээлэнгийн захирлын үүргийг гүйцэтгэгч Л.Тулгаад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СӨРЖМЯДАГ  
М.ЭНХЖАРГАЛ  
Б.ТЭРБИШ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 17/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 2020/61/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Анагаах ухааны хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн санхүүжилтээр худалдан авсан 5,440,000.00 төгрөгийн шатахууныг нягтлан бодох бүртгэлд анхан шатны баримтад үндэслэж бүртгээгүй, нэр төрлөөр бүртгээгүй, зарлагын гүйлгээний дэмжих, нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйл. 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Байгууллагын бараа материалын бүртгэл, тайланг УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу хөтөлж, тайлагнаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, стандарт, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаах ухааны хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Тулгаа, нягтлан бодогч Б.Оюунжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

М.ЭНХЖАРГАЛ  
Б.ТЭРБИШ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Чагтай тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264220

2022.10.20

170.10.10.20.Bishig\_Kherem\_Aiban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazan-SS.Docx

001080186